



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/215

Улаанбаатар хот

Төсөл сонгон шалгаруулалтын хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5.3.8, "Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл сонгон шалгаруулалтын журам"-ын 2.1, 2.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдон ажиллах эрчим хүчний хуримтлуурын төслийг цаашид сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

2. Эрчим хүчний хуримтлуур барих төсөл шалгаруулалт зохион байгуулах үүрэг бүхий хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд.

Хорооны дарга:

Гишүүд

- Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
- Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга
- Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахилгааны хэлтсийн шинжээч
- Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ тарифын газрын дарга (зөвшилцсөнөөр)
- Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн техникийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)
- Диспетчерийн үндэсний төв ТӨХК-ийн горим төлөвлөлт, тооцооны албаны дарга (зөвшилцсөнөөр)
- Монголын эрчим хүчний ассоциацийн ерөнхий нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр)

170606060523

Нарийн бичгийн дарга:

- Монголын эрчим хүчний засаглалын хөтөлбөрийн ахлах мэргэжилтэн, доктор (зөвшилцсөнөөр)
- Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)

3.Төсөл шалгаруулалтын баримт бичиг, төслийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулах, шалгаруулалтыг зохион байгуулах, төслийг шалгаруулсан тухай зөвлөмжийг гаргаж танилцуулахыг төсөл шалгаруулалтын хороонд даалгасугай.

4.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж, төсөл шалгаруулалтын хорооны үйл ажиллагааг мэргэжил аргагүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Н.Тавинбэх/-д даалгасугай.

5.Энэхүү тушаалыг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН